



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 676

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Мэдээлэл технологийн үндэсний парк" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгын 4 дүгээр давхрын их засварын ажлын хүрээнд бий болсон 1,092,462,361.30 (нэг тэрбум ерэн хоёр сая дөрвөн зуун жаран хоёр мянга гурван зуун жаран нэгэн төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгө (засан сайжруулалт)-ийг хавсралтад заасны дагуу хөрөнгийн холбогдох дансанд (капиталжуулан) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Мэдээлэл технологийн үндэсний парк" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Ж.Золзаяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133092823
29-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
676 дугаар тогтоолын хавсралт

“МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1. Барилгын их засвар					
1	Барилгын угсралтын зардал				797,661,657.30
	Хэсгийн дүн				797,661,657.30
2. Тоног төхөөрөмж					
2	Хөргөлтийн тоног төхөөрөмж Qхөр=7.6кВт	1	ш	6,256,690.00	6,256,690.00
3	Хөргөлтийн тоног төхөөрөмж Qхөр=11.3кВт	2	ш	10,543,060.00	21,086,120.00
4	Хөргөлтийн тоног төхөөрөмж Qхөр=15.0кВт	3	ш	13,701,270.00	41,103,810.00
5	Агаар сорох сэнс Vox-ес 50х25	3	ш	5,330,270.00	15,990,810.00
6	Агаар сорох сэнс Ф315	1	ш	3,800,764.00	3,800,764.00
7	Агаар сорох сэнс Ф200	3	ш	1,845,910.00	5,537,730.00
	Хэсгийн дүн				93,775,924.00
3.Лифт					
8	Лифт 630кг-27050\$	2	ш	100,512,390.00	201,024,780.00
	Хэсгийн дүн				201,024,780.00
Нийт дүн					1,092,462,361.30 (нэг тэрбум ерэн хоёр сая дөрвөн зуун жаран хоёр мянга гурван зуун жаран нэгэн төгрөг гучин мөнгө)